


ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ


НЭГ. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2024 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс 2025 оны өдрөөс 10 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар буюу **эпидемиологийн 1-42 дугаар долоо хоногт** нийт Нийслэлийн 7 дүүрэг, 9 аймагт **1732** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан.



Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 1732 тохиолдлын 95% /1649/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 6% /83/ нь орон нутагт (Баян-Өлгий /30/, Дорнод /3/, Орхон /11/, Өмнөговь /9/, Сэлэнгэ /6/, Төв/16/, Дорноговь /4/, Баянхонгор /1/, Дархан /1/, Дундговь /1/) бүртгэгдсэн байна.




Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу **494** тохиолдол Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.

ЭПИДЕМИОЛОГИЙН **42** ДУГААР ДОЛОО ХОНОГТ

(2025.10.12 – 10.18)

2025 оны эпидемиологийн 42 дүгээр долоо хоногт 66 угаарын хийн хордлого бүртгэгдсэн байна. Өмнөх оны мөн үеэс 61 хувиар, 5 жилийн дунджаас 34.6 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.




ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ

Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд **эпидемиологийн 1-42 дүгээр долоо хоногт нийт 1112** иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.


645Эмнэлгийн
тусламж авч буцсан**467**Хэвтэн эмчлүүлж
эдгэрч гарсан**0**

Нас барсан

Эрэгтэй
47%Эмэгтэй
53%

Химийн хордлогыг насны бүлгээр авч үзвэл 0-9 буюу бага насны хүүхдүүд хамгийн их хордлогод өртөж байна.

2025 оны **эпидемиологийн 42 дүгээр долоо хоногт** химийн цочмог хордлогод өртсөн **32** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеээс 10.3 хувиар, сүүлийн 5 жилийн дунджаас 75.82 хувиар тус, тус өссөн үзүүлэлттэй байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (Эпи – 42 долоо хоногт)

№	Шалтгаан (Сэдэл)	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	2	12	14
2	Эмийн хордлого	7	11	18
Нийт		9	23	32

Нийт 32 хордлогын тохиолдол бүртгэгдсэнээс 18 (56.3%) нь эмийн хордлого, 14 (43.7%) нь химийн бодисын хордлого байна. Санамсаргүй хордлого 23 (71.9%) тохиолдлоор, санаатай хордлого 9 (28.1%) тохиолдлоос илүү байна. Энэ нь эм болон химийн бодисыг буруу хэрэглэх, хадгалах дадал сул байгааг илтгэн, урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

-о0о-